Артерийн гипертензийн талаарх эмчлүүлэгчдийн мэдлэгийг үнэлсэн зарим үр дүн

Ли Ли[1], Б.Оюунгоо[1], Г.Ганхуяг[1]

[1]АШУҮИС, Сувилахуйн сургууль
Цахим шуудан: GNU21E004@gt.mnums.edu.mn, Утас: 89868123

Түлхүүр үг:
Мэдлэг
Хүйс
Артерийн гипертензи
Эм

Товч утга:
Үндэслэл: БНХАУ-д хийгдсэн судалгаагаар хүн амын нийт нас баралтын 71 хувийг халдварт бус өвчин (ХБӨ) эзэлж байгаа бөгөөд нас баралтын тэргүүлэх шалтгаан нь зүрх судас, тархины судасны өвчлөл байна. Энэ нь ХБӨ-ний 44 хувийг эзэлж байгаа нь хорт хавдрын өвчлөлөөс хоёр дахин их байна. Улмаар 2030 он гэхэд зүрх судасны өвчнөөр нас барсан хүний нийт тоо 23 саяас давах төлөвтэй байгаа бөгөөд үүний гол шалтгаан нь артерийн даралт ихсэлт, таргалалт, чихрийн шижин өвчний хэв шинж 2 болон бусад хүчин зүйлүүд болоод байна. Халдварт бус өвчний дэлхийн зорилтуудын нэг бол 2010-2030 онд артерийн даралт ихсэх өвчний тархалтыг 33 хувиар бууруулах явдал юм. **Зорилго:** Артерийн гипертензийн талаарх эмчлүүлэгчдийн мэдлэгийг үнэлэх. **Арга, аргачлал:** Халдварт бус өвчний талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх судалгааны стандарт STEPS асуумжаас судалгааны ерөнхий мэдээллийн асуумж, ХБӨ-ний талаарх ерөнхий мэдлэгийн асуумжийг ашигласан. Асуумж судалгааны үнэн магадлалтай болон найдвартай байдлыг шалгаж санамсаргүй түүврийн аргаар 5 эмчлүүлэгчийг сонгон авч асуумжаар ярилцлага хийж, судлаач мэдээлэл цуглуулах дадлага хийж, асуумжын найдвартай байдлыг Кронбах альфа (Cronbach's alpha)-ийн утга нэгрүү дөхөх тусам найдвартай гэж үзсэн. Судлаач судалгааны 51 асуумжийн дагуу эмчлүүлэгчтэй ярилцаж оролцогчийн ойлголт, үзэл бодлоо үнэн зөв илэрхийлэх боломжийг олгож, 1 эмчлүүлэгчтэй 30 минут ярилцаж, судлаач судалгааг бөглөсөн. **Үр дүн:** Судалгаанд Монгол-Хятад эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй 7 аймаг хошууны 43-89 насны 330 эмчлүүлэгчийн n=175 (53%) нь эрэгтэй, n=155 (47%) нь эмэгтэй байв. Амьдарч буй орчныг тодорхойлбол орон сууцанд 188 (57%), гэрт 100 (30%), хашаа байшинд 42 (13%) нь амьдарч байна. Ам бүлийн тооны хувьд 1-5 ам бүлтэй 253 (77%), 6-10 ам бүлтэй 77 (23%), дундаж нас 66.88+12.26 жил, оношлогдсон жилийн дундаж үзүүлэлт 8.39+6.83 байна (p=0.000). Судалгаанд хамрагсдын бүх насны бүлэгт артерийн даралт ихсэлт нь бусад өвчнөөр өвчлөх шалтгаан болдог гэдгийг мэддэг боловч байнгын хяналт хийхгүй, артерийн даралтыг зөв хэмжихгүй (.072) байна. **Дүгнэлт:** Судалгаанд хамрагдагсадын ихэнх хувь нь артерийн даралт ихсэлт нь бусад өвчний суурь болдог, артерийн даралт бууруулах аргуудаас эм хэрэглэх, идэвхтэй хөдөлгөөн хийх чухал гэдгийг мэддэг боловч хэрхэн хэзээ хэмжиж, хэрхэн хянахаа мэддэггүй байгаа эрүүл мэндийн боловсрол олгох шаардлагатай байгааг харуулж байна.

Үндэслэл: БНХАУ-д хийгдсэн судалгаагаар хүн амын нийт нас баралтын 71 хувийг халдварт бус өвчин (ХБӨ) эзэлж байгаа бөгөөд нас баралтын тэргүүлэх шалтгаан нь зүрх судас, тархины судасны өвчлөл байна. Энэ нь ХБӨ-ний 44 хувийг эзэлж байгаа нь хорт хавдрын өвчлөлөөс хоёр дахин их байна. Улмаар 2030 он гэхэд зүрх судасны өвчнөөр нас барсан хүний нийт тоо 23 саяас давах төлөвтэй байгаа бөгөөд үүний гол шалтгаан нь артерийн даралт ихсэлт, таргалалт, чихрийн шижин өвчний хэв шинж II болон бусад хүчин зүйлүүд болоод байна. Халдварт бус өвчний дэлхийн зорилтуудын нэг бол 2010-2030 онд артерийн даралт ихсэх өвчний

тархалтыг 33 хувиар бууруулах явдал юм.

Халдварт бус өвчлөл нэмэгдэж, зүрх судасны өвчлөл, артерийн гипертензи залуужих хандлагатай болж, 30-50 насны хүмүүс илүү өртөж, ялангуяа хүн амын хөгшрөлт, хотжилт хурдацтай байгаа энэ үед Хятадад зүрх судасны өвчлөлд нөлөөлөх хүчин зүйлийн тархалт илэрхий болж, зүрх судасны өвчлөлийн тоо тасралтгүй нэмэгдэж байна. Хятадад 2009-2016 оны статистикаар зүрх судасны өвчнөөр өвчлөгчдийн тоо 290 сая орчим байгаагийн 13 сая орчим нь цус харвалт, 11 сая орчим нь зүрхний титэм судасны өвчин, 5 сая орчим нь уушгины үрэвсэл, 4.5 сая орчим нь зүрхний дутагдал, 2.5 сая орчим нь зүрхний хэрх, 2.5 сая орчим нь төрөлхийн зүрхний гажигтай, 2 сая орчим нь цусны даралт ихсэх өвчтэй, 245 сая орчим нь артерийн гипертензитэй байсан.

Хятадад 2020 онд артерийн гипертензитэй 300 сая орчим хүн байсан бөгөөп хятадын насанд хүрэгчдийн дунд артерийн гипертензийн тархалт 33.5 хувьд, хүн амын дундах цусны даралт ихсэх өвчний талаарх мэдлэг 30.2 хувьд, эмчилгээ 24.7 хувьд, хяналт ердөө 6.1 хувьд хүрсэн байна. ӨМӨЗО-нд эмнэлгийн Зүрх судасны тасгийн эмчид өдөрт 100 үйлчлүүлэгч үзүүлж байгаа бол тэдний бараг 85 нь артерийн даралт ихсэлттэй байна. Артерийн даралт ихсэлттэй 300 гаруй сая хүний 48 хувь нь артерийн даралт ихсэлттэй гэдгээ мэддэггүй, насанд хүрсэн гурван хүн тутмын нэг нь артерийн гипертензигээр шаналж байгаа нь энэхүү судалгааны ажлын үндэсл боллоо.

Зорилго: Артерийн гипертензийн талаарх эмчлүүлэгчдийн мэдлэгийг үнэлэх

Арга, аргачлал: Судалгаанд ӨМӨЗО-ны Бугат хотын Монгол-Хятад эмнэлэгт артерийн гипертензи оношгой 2023 оны 05 дугаар сарын 20-нооc 08 дугаар сарын 01-ний хооронд судалгааг хийж, статистик дүн шинжилгээг SPSS-25 программаар боловсруулав.
Бид нийт 3 сарын хугацаанд 330 эмчлүүлэгчээс асуумж авсан.

$$n = \frac{1200}{1 + 1200(0{,}05)^2} = 300\ (300 \pm 10\% = 300 \pm 30 = 330\ \text{эмчлүүлэгч})$$

Судалгааны ажлын зорилтын хүрээнд эмчлүүлэгчдээс тоон судалгааны аргыг ашиглан ерөнхий мэдээлэл, халдварт бус өвчний талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх судалгааны стандарт STEPS асуумжаас судалгааны ерөнхий мэдээллийн асуумж, ХБӨ-ний талаарх ерөнхий мэдлэгийн асуумжийг ашигласан. Асуумж судалгааны үнэн магадлалтай болон найдвартай байдлыг шалгаж санамсаргүй түүврийн аргаар 5 эмчлүүлэгчийг сонгон авч асуумжаар ярилцлага хийж, судлаач мэдээлэл цуглуулах дадлага хийж, асуумжын найдвартай байдлыг Кронбах альфа (Cronbach's alpha)-ийн утга нэгрүү дөхөх тусам найдвартай гэж үзсэн.

Судлаач судалгааны асуумжийн дагуу эмчлүүлэгчтэй ярилцаж оролцогчийн ойлголт, үзэл бодлоо үнэн зөв илэрхийлэх боломжийг олгож, 1 эмчлүүлэгчтэй 30 минут ярилцаж, судлаач судалгааг бөглөсөн.

Үр дүн: Судалгаанд Монгол-Хятад эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй 7 аймаг хошууны 43-89 насны 330 эмчлүүлэгчийн n=175 (53%) нь эрэгтэй, n=155 (47%) нь эмэгтэй байв. Амьдарч буй орчныг тодорхойлбол орон сууцанд 188 (57%), гэрт 100 (30%), хашаа байшинд 42 (13%) нь амьдарч байна. Ам бүлийн тооны хувьд 1-5 ам бүлтэй 253(77%), 6-10 ам бүлтэй 77 (23%) байна. (Хүснэгт 1).


Хүснэгт 1. Эмчлүүлэгчдийн нас болон артерийн гипертензи өвчнөөр оношлогдсон жилийн үзүүлэлт

Үзүүлэлт		Оношлогдсон жилийн үзүүлэлт (n, (%))				Нийт (n=330)	p утга
		0-9 жилийн өмнө	10-19 жилийн өмнө	20-29 жилийн өмнө	30-39 жилийн өмнө		
Насны үзүүлэлт (n, (%))	40-49 насны эмчлүүлэгч	30 (9)	2 (0.6)	1 (0.3)	-	33 (10)	0.000
	50-59 насны эмчлүүлэгч	62 (19)	12 (3.6)	1 (0.3)	-	75 (22.7)	
	60-69 насны эмчлүүлэгч	58 (17)	21 (6.3)	6 (1.8)	-	85 (25.7)	
	70-79 насны эмчлүүлэгч	25 (8)	23 (7)	11 (3.3)	-	59 (17.8)	
	80-89 насны эмчлүүлэгч	5 (2)	52 (15.7)	17 (5.2)	4 (1.2)	78 (23.6)	

Судалгаанд хамрагдагсадын дундаж нас 66.88+12.26 жил, оношлогдсон жилийн дундаж үзүүлэлт нь 8.39+6.83 жил байлаа (p=0.000).

Судалгаанд оролцогчдын артерийн даралт ихсэлт нь бусад өвчнөөр өвчлөх шалтгаан болдог гэсэн мэдлэг нь бүх насны бүлэгт ач холбогдолтой (p=0.72) байхад хэмжүүлэх шаардлагатай болон хэрхэн зөв хэмжихээ мэддэггүй нь байна. (0.070)

Судалгаанд оролцогчдын артерийн гипертензийн талаарх мэдлэгийг судалсан үр дүнг Зураг 1-т харуулав.



Зураг 1. Судалгаанд оролцогчдын мэдлэгийн үзүүлэлтийг тодорхойлсон дүн (хүйсээр)

Судалгаанд оролцогчдын бүх насны бүлэгт артерийн даралт ихсэлт нь бусад өвчнөөр өвчлөх шалтгаан болдог гэдгийг мэддэг боловч байнгын хяналт хийхгүй, артерийн даралтыг зөв хэмжихгүй байгаа нь тодорхойлогдлоо. (0.072)

Даралт бууруулахад нөлөөлдөг аргуудаас хамгийн үр дүнтэй аргыг мэддэг эсэхийг тодорхойлсон. Судалгаанд оролцогчдын ихэнх нь артерийн даралт бууруулах аргуудаас эм хэрэглэх, идэвхтэй хөдөлгөөн хийх нь илүү нөлөөлдөг хэмээн үзсэн байхад давхардсан тоогоор 35 (11%) нь эм уух, хоолны хэв маягаа өөрчлөх, жингээ бууруулах, идэвхтэй хөдөлгөөн хийх зэрэг нөлөөлөхгүй хэмээн үзсэн байна. Даралт бууруулах эм, хооллолтын хэв маяг, биеийн жин, идэвхтэй хөдөлгөөн нь артерийн даралтыг бууруулахад нөлөөлөхгүй хэмээн үзсэн эмчлүүлэгчдийн 33 (91%) нь эмэгтэй эмчлүүлэгчид тус тус байлаа.

Хэлцэмж: Ази тивийн хэмжээнд ялангуяа Вьетнам, Хятад, Солонгос, Япон, Тайландад сүүлийн 30 жилийн хугацаанд артерийн гипертензи өвчний тархалт (АД140<) нэмэгдсэн байна. Европ, Канад, АНУ-тай харьцуулахад Азийн бүс нутагт артерийн гипертензийн талаарх ойлголт, эмчилгээ, хяналтын байдалд ихээхэн ялгаатай байдаг зарим талаар угсаатны хооллолт, амьдралын хэв маяг, нийгэм-хүн ам зүйн хүчин зүйлсийн ялгаатай байдлаас шалтгаалдаг[10]. Улсын лавлагаа шатлалын эмнэлгийн тасаг, амбулатороор үйлчлүүлсэн артерийн гипертензи гэж оношлогдсон 229 эмчлүүлэгчийг оролцуулсан судалгаагаар насжилт нь артерийн даралт ($p<0.05$) ихсэлттэй хамааралтай байсан[11]. Мөн судалгаанд оролцогчдын 30.8% нь артерийн гипертензи өвчнөөс урьдчилан сэргийлэх боломжтой ($p<0.05$) бөгөөд артерийн гипертензийг хянах зорилтууд, артерийн гипертензитэй холбоотой эрсдэлүүд нь насжилт, хүйс, түргэн хоол, амьтны гаралтай өөх тосны хэрэглээ, архи, тамхины хэрэглээ, артерийн гипертензийн хяналт муу байгаатай холбоотой байна. Өдөр бүр хүнсний ногоо, жимс жимсгэнэ хэрэглэх нь АГ хяналтыг сайжруулж, эрсдлийг бууруулдаг. Эмийн хяналтыг дагаж байгаа хэдий ч АГ-ын оновчтой бус хяналт нь даралт бууруулах эмээс гадна амьдралын хэв маягийг өөрчлөх шаардлагатай, артерийн гипертензийн талаарх эрүүл мэдлэг олгож, эмнэлгийн мэргэжилтний мэдээллээр дамжуулан нас, амьдралын тааламжгүй хэв маягаас шалтгаалан өөрчлөгдөж болох эрсдэлт хүчин зүйлсийг шийдвэрлэх, артерийн гипертензи ихсэхтэй холбоотой мэдээлэл хангалтгүй,

АГ холбоотой мэдээллийг мэдээллийн хэрэгслээр түгээх, эмчлүүлэгчийн картанд цаг товлох нь чухал гэж үзсэн байна. Бидний судалгаагаар артерийн даралт ихсэлт нь бусад өвчнөөр өвчлөх шалтгаан болдог гэсэн мэдлэг нь бүх насны бүлэгт ач холбогдолтой ($p=0.72$) байхад хэмжүүлэх шаардлагатай болон хэрхэн зөв хэмжихээ мэддэгүй(0.070), бүх насны бүлэгт артерийн даралт ихсэлт нь бусад өвчнөөр өвчлөх шалтгаан болдог гэдгийг мэддэг боловч байнгын хяналт хийхгүй, артерийн даралтыг зөв хэмждэггүй (.072) байна.

Бидний судалгаанд оролцогчдын 57.6% (190) хангалттай мэдлэггүй, 42.4% (140) хангалттай мэдлэгтэй байсан нь бусад судлаачдын дүгнэлттэй нийцэж байна. Судалгаанд хамрагсдын ихэнх нь артерийн даралт бууруулах аргуудаас эм хэрэглэх, идэвхтэй хөдөлгөөн хийх нь илүү нөлөөлдөг хэмээн үзсэн байхад давхардсан тоогоор 35 (11%) нь эм уух, хоолны хэв маягаа өөрчлөх, жингээ бууруулах, идэвхтэй хөдөлгөөн хийх зэрэг нөлөөлөхгүй хэмээн үзсэн байна. Даралт бууруулах эм, хооллолтын хэв маяг, биеийн жин, идэвхтэй хөдөлгөөн нь артерийн даралтыг бууруулахад нөлөөлөхгүй хэмээн үзсэн 60-79 насны 33 (91%) эмэгтэй эмчлүүлэгчид байна.

Дүгнэлт: Судалгаанд хамрагсдын ихэнх хувь нь артерийн даралт ихсэлт нь бусад өвчний суурь болдог, артерийн даралт бууруулах аргуудаас эм хэрэглэх, идэвхтэй хөдөлгөөн хийх чухал гэдгийг мэддэг боловч хэрхэн хэзээ хэмжиж, хэрхэн хянахаа мэддэггүй байгаа эрүүл мэндийн боловсрол олгох шаардлагатай байгааг харуулж байна.

Ном зүй:

1. *Хятад улс болон мужийн засаг захиргааны бүсүүдийн өвчлөлийн ачааллын статистик судалгаа, 2009-2016,* 知乎*/zhi hu вэб сайтийн* 麦贽源生汀*/mai zhi yuan sheng ting №332, 22 April, 2022. х. 1-3.*
2. *Нандинцэцэг. Ц нарын Артерийн даралт ихсэлт болон вирүст хепатит хавсарсан үеийн өөх тосны солилцооны үзүүлэлтүүдийг судалсан дүн, ЭМШУ сэтгүүл, Vol.18.(63) 2022, хуу10-14*
3. *Bittner VA, Szarek M, Aylward PE, et al; ODYSSEY OUTCOMES Committees and Investigators. Effect of alirocumab on lipoprotein(a) and cardiovascular risk after acute coronary syndrome. J Am Coll Cardiol. 2020;75(2):133-144. doi:10.1016/j.jacc.2019.10.057*
4. *Adam S. Vaughan, PhD; Fátima Coronado, MD; Michele Caspe, PhD; Fleetwood Loustalot, PhD;*
   Janet S. Wright, MD, County-Level Trends in Hypertension-Related Cardiovascular Disease Mortality United States, 2000 to 2019, J Am Heart Assoc. 2022;11: e024785. DOI: 10.1161/JAHA.121.024785
5. *2020 International Society of Hypertension Global Hypertension Practice Guidelines, Downloaded from http://ahajournals.org by on April 1, 2023*

6. *Cheryl R. Dennison Himmelfarb, RN, ANP, PhD, FAAN, FAHA, FPCNA, Yvonne Commodore-Mensah, RN, PhD, Martha N. Hill, RN, PhD, FAAN, FAHA Baltimore, MD; and Atlanta, GA Expanding the Role of Nurses to Improve Hypertension Care and Control Globally, VOL. 82, NO. 2, 2016, ISSN 2214-9996, http://dx.doi.org/10.1016/j.aogh.2016.02.003*
7. *Woo-Seok Choi, Nam-Suk Kim, Ah-Young Kim and Hyung-Soo Woo, Nurse-Coordinated Blood Pressure Telemonitoring for Urban, Hypertensive Patients: A Systematic Review and Meta-Analysis, International Journal of Environmental Research and Public Health | An Open Access Journal from MDPI*
8. *Briar McKenzie MDiet, Joseph Alvin Santos MPhil, Kathy Trieu MPH, Sudhir Raj Thout MA, Claire Johnson PhD, JoAnne Arcand PhD RD, Jacqui Webster PhD, Rachael McLean BA MBChB MPH PhD The Science of Salt: A focused review on salt-related knowledge, attitudes and behaviors, and gender differences, DOI: 10.1111/jch.13289, wileyonlinelibrary.com/journal/jch*
9. *В. Даваахүү нарын Артерийн гипертензийн үеийн сувилахуйн тусламж ба эрүүл мэндийн боловсрол олгох арга зүй, УБ 2023*
10. *Samuel Kimani, Waithira Mirie, Margaret Chege, et al. Association of lifestyle modification and pharmacological adherence on blood pressure control among patients with hypertension at Kenyatta National Hospital, Kenya: a cross-sectional study. 2019; 9(1): e023995. [PMC free article] [PubMed] [Google Scholar]*
11. *Norm RC Campbell, Aletta E Schutte, Cherian V Varghese, et al. [São Paulo call to action for the prevention and control of high blood pressure: 2020 Llamado a la acción de San Pablo para la prevención y el control de la hipertensión arterial, 2020]. 2021; 44: e27. [PMC free article] [PubMed] [Google Scholar]*

Some results of assessing patients' knowledge about hypertension

Li Li[1], Oyuungoo B[1], Gankhuyag G[1]

[1]School of Nursing, MNUMS
E-mail: GNU21E004@gt.mnums.edu.mn, Tel: +976-80373646

Background: According to a study conducted in China, non-communicable diseases (NCDs) account for 71% of the total population deaths, and cardiovascular and cerebrovascular diseases are the leading causes of death. It accounts for 44% of NCDs, which is twice higher than the incidence of cancer. As a result, by 2030, the total number of deaths from cardiovascular diseases is expected to exceed 23 million, the main causes of which are hypertension, obesity, type II diabetes and other factors. One of the global targets for non-communicable diseases is to reduce the prevalence of hypertension by 33 percent between 2010 and 2030.
Aim: To assess the patient's knowledge about arterial hypertension.
Materials and Methods: A survey general information questionnaire and a general knowledge questionnaire about NCDs were used from the standard STEPS questionnaire to assess population knowledge, attitudes, and practices about noncommunicable diseases. To check the validity and reliability of the questionnaire, 5 therapists were randomly selected and interviewed by the questionnaire, the researcher practiced data collection, and the reliability of the questionnaire was considered to be reliable as the value of Cronbach's alpha approached one. The researcher conducted an interview with the patient according to the 51 questions of the study in such a way as to allow the participant's understanding and opinion to be accurately expressed, and when taking the survey, researcher talked with one participant for about 30 minutes and took the survey.
Results: The study included 330 patients aged 43-89 years from 7 provinces in Mongolia-China hospitals, of which n=175(53%) were male and n=155(47%) were female. As for the living environment, 188 (57%) live in an apartment, 100 (30%) live in ger a, and 42 (13%) live in a house. Regarding the number of families, 253 (77) have 1-5 families, 77 (23) have 6-10 families, the average age is 66.88+12.26, and the average year of diagnosis is 8.39+6.83 (p=0.000). The knowledge of the participants that hypertension is a cause of other diseases is significant (p=0.72) in all age groups, while the knowledge of the need to measure and how to measure correctly is (0.070). All age groups of participants know that high blood pressure is a cause of other diseases, but they do not regularly monitor and measure blood pressure correctly (072).
Conclusion: Most of the participants know that high blood pressure is the basis of other diseases and the use of drugs and active movement are important methods of lowering blood pressure, but they do not know how to measure and control it, which indicates the need for health education.

Keywords: Knowledge, Gender, Arterial hypertension, Drugs